

**"МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2016 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН
ЧИГЛЭЛ БАТЛАХ ТУХАЙ" УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСЛИЙГ АНХНЫ
ХЭЛЭЛЦҮҮЛЭГТ БЭЛТГЭСЭН ТАЛААР ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНООС ГАРГАСАН САНАЛ, ДҮГНЭЛТ**

2015 оны 5 дугаар
сарын 12-ны өдөр

Улаанбаатар
хот

**Илтгэгч нь: Улсын Их Хурлын
гишүүн Д.Ганхуяг**

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн "Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийг Төсвийн байнгын хороо 2015 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Төслийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Б.Чойжилсүрэн үндсэн чиглэлд дотоод өрийн хэмжээг бууруулах, бизнес эрхлэгчдэд төрийн бодлогыг ойлгомжтой байхаар тусгах, Улсын Их Хурлын гишүүн Ч.Улаан Засгийн газрын зардлыг бууруулах болон хямралаас гарах нөхцөлд зохицсон бодлогыг тодорхойлох, Улсын Их Хурлын гишүүн Ч.Хүрэлбаатар төсвийн тодотголоор дотоод зээллэгийг бууруулах, тэглэх асуудлыг яаралтай хэлэлцүүлэх, мөн үндсэн чиглэлд томоохон төслүүдийг хэрэгжүүлж эхлэх, бизнесийн орчныг сайжруулахыг дэмжсэн бодлогуудыг тусгах, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганхуяг 2015 оны төсвийн тодотголыг батлахад цахилгаан, эрчим хүч, ган, нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэж, экспортлох талаар өмнөд хөрштэй хамтарч ажиллах чиглэлийг Засгийн газарт өгснийг үндсэн чиглэлд тусгах хэрэгтэй гэсэн саналуудыг гаргасан бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдээс тогтоолын төслийн талаар зарчмын зөрүүтэй санал гараагүй болно.

Төсвийн байнгын хороо Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь хэсэгт заасны дагуу Эдийн засгийн байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлж, тус Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Д.Ганхуяг танилцуулахаар тогтлоо.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

"Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг хийсэн талаар Төсвийн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

**ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА**

Б.БОЛОР

